



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

Ж.Эрүү оны 06 сарын 12 өдөр

Дугаар 1/29

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.6.1, 3.6.3 дахь заалт, “2024 оны төсөв батлах тухай” сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 8 дугаар хавсралтын 13 дахь хэсгийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Үнэлгээний хорооны 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01 дүгээр дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн Ойн хөнөөлт шавжаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, үүргийн шүршигч багжаар хортон устгалын ажлыг “Грандфорест” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2. Тендерт шалгарсан “Грандфорест” хязгаарлагдмал хариуцлагатай компанийтай гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.


3. Зардалд шаардагдах 303,000,000 (гурван зуун гурван сая) төгрөгийг гэрээний дагуу, Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч гэрээний дагуу санхүүжилт өгөхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/



022301173